

АГУУЛГА

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:	2
1.2 Төслийн дэд бүтэц, тоног төхөөрөмж.....	3
ХОЁР. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	5
2.1 Төслийн болзошгүй нөлөөлөл	5
2.2 Төслийн талбайн байршил, газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх болзошгүй нөлөөлөл	7
2.3 Агаарын чанарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл	7
2.4 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нөлөөлөл.....	8
2.5 Гадаргын болон газрын доорх усан нөлөөлөх нөлөөлөл.....	8
2.6 Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл	9
2.7 Төслөөс бий болох хог хаягдлын нөлөөлөл	9
ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
3.1 Зорилго.....	10
3.2 Зорилт.....	10
3.3 Хамрах хүрээ:	10
3.4 БОМТ-ний дэлгэрэнгүй	12
ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь	5
Хүснэгт 2 Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл	7
Хүснэгт 3 Төслийн газрын гадарга, газрын хэвлийтэй холбоотой нөлөөлөл	7
Хүснэгт 4 Агаарын чанарын үзүүлэлт	7
Хүснэгт 5 Төслийн хөрсөн бүрхэвчтэй холбоотой нөлөөлөл.....	8
Хүснэгт 6 Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ	8
Хүснэгт 7 Төслийн ургамлан нөмрөгтэй холбоотой нөлөөлөл.....	9
Хүснэгт 8 Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөв.....	11
Хүснэгт 9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	17

Зургийн жагсаалт

Зураг 1 Талбайн байршлын зураг	2
Зураг 2 Төслийн талбайн хуваарилалт	3
Зураг 3 Барилгын ажлын явц 2024.10 сар	3
Зураг 4 2024 оны 9 сарын байдлаар	4
Зураг 5 2024 оны 10 сарын байдлаар	4
Зураг 6 2024 оны 12 сарын байдлаар	5

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Төслийн нэр	“Хүслийн төгөл” аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч	“МОНГОЛ УГСАА КОНСТРАКШН” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011425104
Регистрийн дугаар	5733839
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 8-р хороо, Жамсранжав гудамж, 45 байр, 17 тоот. Утас: 99245555
Төсөл хэрэгжүүлэх байршил	Богдхан уулын ДЦГ-ын Хүүшийн аманд. (ХУД, 4 дүгээр хороо)

Зураг 1 Талбайн байршлын зураг



1.2 Төслийн дэд бүтэц, тоног төхөөрөмж

Цахилгаан хангамж: “УБЦТС” ТӨХК-ний 2020 оны 08 сарын 27-ны өдрийн №03/2020/87 тоот техникийн нөхцөлийн дагуу нэгдсэн сүлжээний өндөр хүчдэлийн шугамаас хангана.

Дулаан хангамж: “Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар”-ын 2023 оны 05 сарын 16-ны өдрийн №013/2023 тоот техникийн нөхцөлийн дагуу төвийн шугамаас хангахаар төлөвлөсөн. Нийт хэрэглээ 4,20 Гкал/цаг байна.

Усан хангамж: “Ус сувгийн удирдах газар”-ын 2018 оны 09 сарын 19-ны өдрийн техникийн нөхцөлийн дагуу төвийн шугамаас хангана. Усны техник нөхцөлд үндэслэн цэвэр усны нийт хэрэглээ 320,0 м³/хон, галын усны хэрэглээ 5,0 л/сек-ээр авав.

Бохирын шийдэл: Төслийн үйл ажиллагаанаас гарах шингэн хаягдлыг төвийн шугамд нийлүүлнэ.

Бүтээн байгуулалтын үеийн хог хаягдал: Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хог хаягдал зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” Монгол улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Энгийн хог хаягдал нь төлөвөөсөө хамаараад хатуу шингэн гэсэн төлөв гарна. Төслийн хүрээнд гарах энгийн хатуу шингэн хог хаягдлыг холбогдох төр захиргааны төв байгууллагаас гаргасан норм нормативын дагуу тооцоолон бодож гаргав. Төслийн хэмжээнд нийт 30 ажилтан ажиллах бөгөөд ажилчдаас болон барилгын үйл ажиллагаанаас гарах хогийг ангилсан байдлаар гарах тоо хэмжээг тооцоолон дараах хүснэгтүүдээр харуулав.

Төслийн нэр:	Хүслийн төгөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Монгол угсаа констракшн” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011425104
Регистрийн дугаар:	5733839
Төслийн байршил:	УБ, ХУД, Богдхан уулын ДЦГ
Утас:	99058480
Ашиглах нийт талбай:	58270.6 м ²
Барилга төлөвлөлт талбай:	17523.5м ² (30.0%)
Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж:	17400.0м ² (29.8%)
Авто зам, авто зогсоолын талбай:	14567.7м ² (25.0%)
Бусад талбай:	8779.4м ² (15.0%)

Зураг 2 Төслийн талбайн хуваарилалт



Зураг 3 Барилгын ажлын явц 2024.10 сар



Зураг 4 2024 оны 9 сарын байдлаар



Зураг 5 2024 оны 10 сарын байдлаар



Зураг 6 2024 оны 12 сарын байдлаар

ХОЁР. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

2.1 Төслийн болзошгүй нөлөөлөл

“Монгол угсаа констракшн” ХХК-ийн “Хүслийн төгөл” төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг магадлан жагсаах аргаар тодорхойлсон.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж үр дүнг хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х” болон “+”-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх байдлыг үзүүлдэг.

Төсөл хэрэгжих Богдхан Уулын ДЦГ-ын Хүүшийн ам орчмын нутаг дэвсгэрт учирч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлж хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1 Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
Нэг. Агаар орчин			
1.1	Тоосжилт	Тээвэрлэлт (үйлчлүүлэгчид, барилгын ажлын болон ахуйн хэрэгцээний бүх төрлийн хангамж, түлш, хог хаягдал)	Улирлын чанартай, тархах хүрээ хомс, хатуу хучилттай замаар төслийн талбай хүрдэг.
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа, угаар	Автомашин	Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал

Хоёр. Усан орчин			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	- Ахуйн болон шатах тослох материалын хаягдал - Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал - Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих	- Голын ус бохирдох, ширгэх - Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай. - Хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулна.
Гурав. Хөрс			
3.1	Элэгдэл, эвдрэл,	Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	- Хэмжээ хязгаарлагдмал - Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болно - Хөрс эвдэрч элэгдэж болно. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.
3.2	Бохирдол	Ахуйн хог хаягдал	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар өөрчлөгдөнө.
Дөрөв. Ургамал бүрхэвч			
4.1	Ургамлын талхагдал	Автомашин болон явган хүний зам	Хэмжээ хязгаарлагдмал
4.2	Ургамлын нөмрөг устах	Нэн ховор, ховор ургамлыг таньж мэдэхгүй устгах	- Төрөл, зүйл өөрчлөгдөж болно. - Төрөл, зүйл устаж болно. - Хэмжээ хязгаарлагдмал болно.
4.3	Хордолт	Шатах тослох материал алдах, гоожих	- Ургамлын биомассын хэмжээ багасна - Ургамлын бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно - Ургамлын генд өөрчлөлт орж болно
4.4	Талхлагдах	- Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зөрөг зам, жим, - Ашиглалтын талбай, барилга объектуудын орчин	- Ургамлын төрөл зүйл устаж болно - Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
Тав. Ан амьтан			
5.1	Хордолт	Шатах тослох материалын болон ахуйн хаягдал	- Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэж болно. - Амьтдын удамшил генд өөрчлөлт орох магадлалтай.
Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин			
6.1	Тоглоомын төв, Амралтын төв, Семинар хурлын тэнхим	Эдийн засгийн чадавх дээшилнэ.	Хүний танин мэдэхүйд дэвшилттэй, соёлыг түгээх зэрэг эерэг нөлөө их
6.2	Үндсэн хөрөнгө	Татварын эх үүсвэр	Улсын төсөвт хувь нэмэр оруулах
6.3	Шинээр ажиллагсад авах	Ажлын байр шинээр бий болно.	- Орон нутгийн иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлнэ. - Тогтмол бус

2.2 Төслийн талбайн байршил, газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Одоогийн байдлаар төсөл хэрэгжиж талбай нь барилгын үйл ажиллагаа явагдаж байгаа, төсөл архитектурын зургаар орчны тохижилт, цэцэрлэгжилт бүрэн хийгдэж оршин суугчид амьдрах таатай орчин бүрдэхээр төлөвлөгдсөн.

Хүснэгт 2 Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	Тийм
Хүний нөлөө болон байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий эсэх	Цаг уурын өөрчлөлтөд нөлөөллийн эрчим дунд. Орон нутагт хүчтэй салхи шуурга болох магадлал бага, салхи, шуурга болсон тохиолдолд нөлөөллийн эрчим бага. Үер, усны болзошгүй эрсдэл бага. Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл бага.
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	Байхгүй. Газрын эзэмших эрх 15 жилээр сунгагдсан.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх хуримтлагдах нөлөөлөлд түүхий эд, ажлын байрны физик бохирдол тус тус хамаарна. Барилгын ажлын явцад материал тээвэрлэх тээврийн хэрэгслийн тоосжилт их.

Хүснэгт 3 Төслийн газрын гадарга, газрын хэвлийтэй холбоотой нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Барилга байгууламжуудаар газрын гадарга нөлөөлөлд өртөх			х	
2	Хатуу, шингэн хог хаягдал хөрсөнд алдагдаж, газрын гадарга бохирдож болзошгүй	х			
3	Байршилтай холбоотой нөлөө	х			
	Нийт	2	1		
Хэсгийн дүгнэлт: Нийт нөлөөллийн 66.7 хувь нь бага ангилалд, 33.3 хувь нь дунд ангилалд багтаж байгааг үндэслэж тухайн төсөл хэрэгжих орчны газарзүй, ландшафт, байршил, геологи орчинд газрын хэвлий, газрын гадаргад Бага зэргийн эрчимтэй нөлөөлөл үзүүлэхээр байна гэж үзэж байна.					

2.3 Агаарын чанарт үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Төсөл хэрэгжиж байгаа Хан-Уул дүүргийн агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, PM10 нарийн ширхэгт тоосонцор, PM2.5 тоосонцор зэргийн хэмжээ нь стандарт хэмжээнээс даваагүй, шаардлага хангаж байна.

Хүснэгт 4 Агаарын чанарын үзүүлэлт

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Төслийн талбайн хэмжилт
	Хүлцэх агууламж, мг/м ³	
Хүхэрлэг хий, SO ₂	0.450	0.021
Азотын давхар исэл, NO ₂	0.200	0.015
Нийт тоос	0.500	0.094
Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	10000	-
Дуу чимээ /ДБА/	60	58

Тус төслийн талбай орчимд хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөр болон зөвшөөрөх хэмжээнээс хэтрэх нөхцөл үүсээгүй байна. Агаар бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн гаралтай, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 ерөнхий хэсэгт хувааж үздэг.

Төслийн талбай орчмын бүсэд агаар бохирдуулагч бодис, агаарын чанарын үзүүлэлтийн мэдээг үндэслэн үзэхэд уг төслөөс агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөлөл бага гэж үзэж болно. Төсөл хэрэгжиж байгаа дүүрэг тухайн хэсэг нь Улаанбаатар хотын бусад дүүрэг хэсгүүдээс агаарын чанар, орчны бохирдол зэргийн үзүүлэлтүүд нь харьцангуй бага гардаг тул уг нутаг дэвсгэрт орон сууц, барилга, үйлчилгээний газар барих, үйл ажиллагаа явуулах зэрэгт нь ашигтай бүс болох юм. Мөн цаг уур, уур амьсгалын нөхцөл байдлаас шалтгаалан төсөл хэрэгжих үйл явцад учрах хүндрэл, болзошгүй эрсдэл үүсэхгүй. Төслөөс шалтгаалсан цаг уур, уур амьсгалын явцад нөлөөлөх нөлөөлөл байхгүй бөгөөд мэргэжлийн байгууллагын өгсөн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөгөөг даган баримталж үйл ажиллагаандаа тусган өгснөөр хүрээлэн буй орчинд хохирол багатай, учирч болох эрсдэлийг сааруулах зэрэг давуу талтай болох юм.

2.4 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид дараах нөлөөлөл үүснэ. Төслийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хог хаягдлыг хаях, ус зайлуулах суваг шуудуу татах гэх мэт үйл ажиллагаанаас үүдэн хөрсөн бүрхэвч шууд ба шууд бус байдлаар элэгдэл эвдрэлд орсон. Элэгдэл, эвдрэлд орж суларсан хөрс шорооноос агаарын бохирдол үүсэх бас нэгэн нөхцөл болно.

Хүснэгт 5 Төслийн хөрсөн бүрхэвчтэй холбоотой нөлөөлөл

Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
	Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц
Барилга барих үйл ажиллагаа				х	
Тээврийн хэрэгсэл хөдөлгөөн				х	
Дэд бүтэц /авто зам, зогсоол, тоглоомын талбай г.м/			х		
Хог хаягдал		х			
Нийт		1	1	2	
Хувиар		25	25	50	

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол нөлөөллүүд нь барилга байгууламж барих үйл явц, хог хаягдал, амрагчдын болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагаатай шууд хамааралтай.

2.5 Гадаргын болон газрын доорх усан нөлөөлөх нөлөөлөл

Уг төсөл хэрэгжих явцад газрын гадаргын усанд шууд нөлөөлөл байхгүй. Газрын гүний усанд дам нөлөөлөл үзүүлнэ. Төслийн үйл ажиллагааны улмаас ахуйн хог хаягдал, барилгын хог хаягдал зэргээс шалтгаалж хөрс болон гүний усанд бохирдол үзүүлж болзошгүй.

Хүснэгт 6 Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Эх үүсвэр	Нөлөөлөл		
	Эрчим	Хамрах хүрээ	Үргэлжлэх хугацаа
Төслийн ус хэрэглээ	Бага	Төслийн талбайн орчинд	Төслийн үйл ажиллагааны турш
Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал	Бага	Цэвэрлэх байгууламжийн шугам	
Автомашинны ШТМ алдагдах	Бага	Төслийн талбайн орчимд	

2.6 Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл

Төслөөс ургамлан нөмрөгт дараах байдлаар нөлөөлнө. Үүнд:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно.
- Төслийн үйл ажиллагааны бүсэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалан тэр орчмын газар талхагдалд өртөж ургамлан нөмрөг устгах
- Барилга байгууламж барих, зэрэг ахуйн болон бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл хувьсаж өөрчлөгдөнө.

Дээрх зурагт харуулсанчлан төсөл хэрэгжих талбайн нийт 45%-д зам талбай, ногоон байгууламж хийхээр зохион байгуулагдсан. Ногоон байгууламжийн хувьд 20 хүртэл хувийг хамруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 7 Төслийн ургамлан нөмрөгтэй холбоотой нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Барилга байгууламжийн улмаас ургамлан нөмрөгт нөлөөлсөн байдал		х		
2	Талбай доторх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн		х		
3	Хатуу шингэн хог хаягдал	х			
Нийт		1	2		
Хэсгийн дүгнэлт : Нийт нөлөөллийн 33.3 % нь бага, 66.7 % нь дунд зэрэг нөлөөлөлтэй гэсэн үнэлгээтэй байгаа нь ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл “Дунд” зэрэг байгааг харуулж байна.					

2.7 Төслөөс бий болох хог хаягдлын нөлөөлөл

- Хог хаягдлыг удаан хөрсөн дээр байлгаснаар хөрсөнд бохирдол үүсэх
- Барилгын ажлын явцад үүссэн хог хаягдлыг тухай бүрд нь зайлуулаагүйгээс болж ажил хийх нөхцөлд саад учруулах, ажилчид бэртэх гэмтэх
- Ахуйн хэрэглээний хог хаягдлыг ил задгай хаяснаас үүдэн хөрс бохирдох, орчны үзэмжийг доройтуулах
- Хог хаягдлыг ил задгай шатааснаас болж утаа гарах, агаар бохирдох
- Ахуйн хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийгээгүй байх, хог хаягдлыг удаан хадгалснаас болж нян бактери үржих, орчныг бохирдуулах, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх
- Хогийн савыг тохиромжгүй газар байрлуулах, эсвэл хогийн савны тоо цөөхөн байх тохиолдолд оршин суугчид хогийг ил задгай хаях, орчныг бохирдуулах

Төслөөс гарах шингэн хог хаягдал:

Төслийн барлигийн ажлын үед гарах шингэн хог хаягдал харьцангуй бага. Ил нүхэн жорлон байхгүй. Төслийн ажилчид байрлах байр болон усанд орох өрөө, 00-ыг төслийн талбайд шийдсэн. Энэ нь НЗД-ын захирамж /А/834/-ыг зөрчөөгүй байна.

ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн

хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Монгол угсаа констракшн” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.3, Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ыг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу “Бурхан Буудай Бүтээмж” ХХК боловсруулав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Монгол угсаа констракшн” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг 2024 оны 02 сарын 26-ны өдрийн 06/905 тоот албан тоотоор ирүүлсэн 2024/АЗ-11 дугаартай Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлага, БОННУ-ны тайланд тусгасан менежментийн дагуу боловсруулсан болно. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав.

БОМТ-ний биелэлтийг НБОГ-аар холбогдох хяналтын байцаагчаар хянуулан батлуулна

3.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

3.2 Зорилт

- БОЕҮ-гээр дүгнэгдсэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
- Нөлөөллийн бүсийн иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцөлийг бүрдүүлж хамтран ажиллах
- Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

3.3 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, ан амьтныг хамгаалах, үргэж зайлахаас сэргийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 8 Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөв

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төлөвлөсөн /мян. т/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	3,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол , Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18,000.0
8	Удирдлага зохион байгуулалт	-
9	БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	150.0
Нийт		28,150.0

3.4 БОМТ-ний дэлгэрэнгүй

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Төлөвлөсөн зардал, мян.төг	Тайлбар
	1	2	3	5	6	7	8
1	Агаарын чанар	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүд оношилгоог тогтмол хийлгэх	Төслийн хүрээнд	500	1	500.0	Агаарын тухай хууль, MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Ус бохирдуулсны төлбөр төлөх /төлбөрийн баримт/	Төслийн хүрээнд	-	-	ҮА-ны зардлаар	Усны тухай хууль, 24.2; 28.4-д үндэслэх
3		Барилгын ажлын үеийн шүүрлийн ус татан зайлуулсан төлбөрийг нөхөн төлөх	Төслийн хүрээнд	-	-	ҮА-ны зардлаар	
4		Төслийн талбайн гадна орчинд цэвэрлэгээ хийх, нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох. /зурган баримт/	Төслийн талбайгаас гадна 50 м-т	-	-	-	
5	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Хог хаягдлыг гэрээний дагуу ачуулах, ангилан ялгах тасалгаат хогийн сав байршуулах /зураг, төлбөрийн баримт/	Төслийн талбайд	-	-	-	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
6		Авто зогсоолын хэсгийг тэмдэгжүүлэх /зурган баримт/	Төслийн талбайд	-	-	1,500.0	
	Нийт					2,000	

2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Төлөвлөсөн зардал, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7
1	Нөхөн сэргээлт	Төслийн талбайд ногоон байгууламжийг төлөвлөлтийн дагуу хийх /зураг, мөнгөн зардлын баримт/	ш	100	3,000	3,000.0	MNS 5914-2008- Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт. MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
2		Төслийн талбайд орчны тохижилт хийх, зам талбай засах /зураг, мөнгөн зардлын баримт/	-	-	-	-	
Нийт						3,000.0	

3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй.

4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Төслийн талбай нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт, суурьшлын бүсэд хэрэгжиж байгаа тул нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө гаргах шаардлагагүй.

5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Монгол улсын өв соёлын шинжтэй, түүхэн дурсгалт олдвор, эд зүйл олдох, илрэх тохиолдол экологийн цагдаа болон Соёлын өвийн үндэсний төвд мэдэгдэж арга хэмжээ авах шаардлагатай.

6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Төлөвлөсөн зардал, мян.төг	Зарцуулсан, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах, /төлбөрийн баримт/	Төсөл хэрэгжих талбай	-	5,000.0		Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай.
2		Анхны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан байршуулах /төлбөрийн баримт, зураг/	Төсөл хэрэгжих талбай	-	-	-	
3		ХАБЭА-н сургалтыг тогтмол зохион байгуулах /ирцийн бүртгэл, зураг/	Төсөл хэрэгжих талбай	-	-	-	
4		Галын аюулгүй байдлын хяналт /хяналтын баримт бичигээр баримтжуулна/	Төсөл хэрэгжих талбай	-	-	-	
	Нийт				5,000.0	0.0	

7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Төлөвлөсөн зардал, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	6	7	8
1	Энгийн хог хаягдал	Хотхоны хогийн цэгийг иргэд хогоо ангилан ялгаж хаях нөхцөлөөр хангаж тохижуулсан байх.	Төсөл хэрэгжих талбай	-		-	10,500.0	Хог хаягдлын тухай хууль; UCS 1703ААюултай хог хаягдлын менежмент; UCS 1701АХог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент
2		Орчны тохижилтод анхаарч хогийн савыг зохих хэсгүүдэд байршуулах.	Төсөл хэрэгжих талбай	-		-	2,500.0	
3		Барилгаас гарах хог хаягдлыг гэрээний дагуу ачуулах, төлбөрийг цаг тухайд төлөх.	Төсөл хэрэгжих талбай	-		10	5,000.0	
	Нийт						18,000.0	

8. Удирдлага зохион байгуулалт ба осол эрсдэлийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үүсэж болзошгүй гэнэтийн осол аваар, галын аюул, цахилгаан техникийн гэмтэл.	Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн хэмжээнд	-	батлуулсан байх	Байгаль орчны тухай хууль
2		Компанийн удирдлагуудыг "ХАБЭА сургалт - компанийн удирдлагад чиглэсэн" сургалтад хамруулах.	Удирдлагууд	1000	1 удаа	
3	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Байгаль орчин хамгаалах, иргэд олон нийтэд таниулах, хог ангиллын талаар хороотой хамтран иргэд рүү чиглэсэн сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	-	тухай бүр	
	Нийт зардал /мян/төг/			1000.0		

ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Монгол угсаа констракшн” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу “Монгол угсаа констракшн” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сард холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Монгол угсаа констракшн” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт 9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Төлөвлөсөн зардал, мян.төг	Тайлбар
	1	2	3	4	5	7
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын (NO2, SO2, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх / БОТЛ мэргэжилтэн хөлслөн хийлгэнэ. /	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох	Жилд нэг удаа	1	50	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдан 2010 оны А/618 дугаар тушаал.
1.2	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Жилд нэг удаа	1		MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
1.3	Дуу шуугиан, чичиргээ: Хүнд даацын машины тээврийн зам, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		Жилд нэг удаа	1		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны шинжилгээ – Ерөнхий үзүүлэлт	Шугамын ус	Жилд нэг удаа		50	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2005
2.2	Усны шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/	Шугамын ус	Жилд нэг удаа	1		
2.3	Усны шинжилгээ – Микробиологи	Шугамын ус	Жилд нэг удаа	1		
Хөрсний бохирдол						
3.1	Хөрсний шинжилгээ – Агро хими	Төслийн талбайд 1 цэг сонгох	Жилд нэг удаа	1	50	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 5850:2029 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.2	Хөрсний шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/	Төслийн талбайд 1 цэг сонгох				
Нийт					150	